

ТЭЭВЭРЛЭГЧИЙН ИТГЭМЖЛЭЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмаар “Хөдөө аж ахуйн Бирж” /цаашид “Бирж” гэх/-ээр арилжаалах бараа, түүхий эд /цаашид “биржээр арилжаалагдсан бараа” гэх/-ийг тээвэрлэх Монгол улсын нутаг дэвсгэрт болон улс хооронд автотээврийн хэрэгслийг ашиглан ачаа тээвэрлэлтийн ажил, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагад итгэмжлэл олгох, итгэмжлэгдсэн тээврийн компани /цаашид “тээвэрлэгч” гэх/-ийн “биржээр арилжаалагдсан бараа”-ны хүргэлтэд тавигдах шаардлага, хүлээх эрх, үүргийг тодорхойлж, түүнтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2 Биржээр арилжаалагдсан барааг итгэмжлэгдсэн тээвэрлэгч тээвэрлэнэ.
- 1.3 Итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн үндсэн зорилт нь “биржээр арилжаалагдсан бараа” - ны тээврийн хэрэгцээг бүрэн хангаж, ачааны чанар, бүрэн бүтэн байдлыг ханган гэрээгээр тохиролцсон хугацаанд тээвэрлэхэд чиглэгдэнэ.
- 1.4 Энэхүү журам, түүний нэмэлт өөрчлөлт, хүчин төгөлдөр мөрдөж эхлэх хугацааг биржийн Гүйцэтгэх удирдлага батална.
- 1.5 Биржийн гүйцэтгэх удирдлагын шийдвэрт өөрөөр тусгаагүй бол энэхүү журам, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг хүчин төгөлдөр мөрдөж эхлэх өдрөөс ажлын 5 өдрийн өмнө Биржийн мэдээллийн сувгаар дамжуулан нийтэд мэдээлнэ.
- 1.6 Энэхүү журмын хавсралтууд нь журмын салшгүй хэсэг байна.

Хоёр. ТЭЭВЭРЛЭГЧИЙН ИТГЭМЖЛЭЛ ОЛГОХ

- 2.1 Биржээс тогтоосон тээврийн итгэмжлэлийн шалгуурыг хангаж, “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн бирж”-ийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд Биржтэй хамтран ажиллах тээвэрлэгч байгууллагад Биржийн Гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр итгэмжлэл олгоно.
- 2.2 Итгэмжлэл хүсэгч нь энэхүү журмын Хавсралт.1-т заасан шалгуур үзүүлэлтийг хангасан байна.
- 2.3 Итгэмжлэл хүсэгч нь Хавсралт.2-т заасан бичиг баримтыг бүрдүүлнэ.
- 2.4 Итгэмжлэл хүсэгч энэхүү журамд заасан шалгуур үзүүлэлтүүд болон бичиг баримтын бүрдлийг хангасан эсэхийг үндэслэн Бирж тээвэрлэгч компанид итгэмжлэл олгоно. Итгэмжлэлийг Биржээс олгосон итгэмжлэлийн гэрчилгээгээр баталгаажуулна.
- 2.5 Бирж итгэмжлэл хүсэгчийн бичиг баримтын бүрдлийг хүлээн авснаас хойш ажлын 20 өдөрт багтаан итгэмжлэл олгох эсэхийг шийдвэрлэнэ.
- 2.6 Бирж шаардлагатай тохиолдолд итгэмжлэл хүсэгчээс нэмэлт материал шаардах эрхтэй бөгөөд шаардлагатай гэж үзвэл итгэмжлэл олгох шийдвэр гаргах хугацааг ажлын 10 өдрөөр сунгаж болно.

- 2.7 Бирж тээвэрлэгчийн итгэмжлэлийг нэг жилийн хугацаатай олгох бөгөөд ээлжит шалгалтаар хугацааг дахин нэг жилээр сунгаж болно.

Гурав. ИТГЭМЖЛЭГДСЭН ТЭЭВЭРЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 3.1 Итгэмжлэгдсэн тээвэрлэгч нь Биржээр арилжаалагдсан барааг худалдан авсан харилцагчтай ачилт, буулгалт, маршрут, тээвэрлэлтийн нөхцлийг тохирч, тээвэрлэлтийн гэрээг байгуулсан байна.
- 3.2 Итгэмжлэгдсэн тээвэрлэгч нь бараа, түүхий эдийг ачиж, тээвэрлэлт хийж эхэлснээс хойш хүлээн авах агуулахад буулгаж, бараа хүлээлцсэн баримт үйлдэх хүртэл хугацаанд тээвэрлэж буй бараа, түүхий эдийн чанар, хэмжээ, бүрэн бүтэн байдлыг хариуцна.
- 3.3 Тээвэрлэгчийн итгэмжлэл авсан тээвэрлэгч нь тээвэрлэлт гүйцэтгэх тутамдаа ачааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг “Хөдөө аж ахуйн Бирж”-ийн ТТЛХ-т ирүүлж мэдээ тайланд тусгуулна. /Хавсралт 3/
- 3.4 Итгэмжлэгдсэн тээвэрлэгч нь Монгол Улсын тээврийн хэрэгслийн тоо бүртгэл, техникийн улсын үзлэгт хамрагдсан, албан татвар, даатгалыг бүрэн төлсөн, осол зөрчилгүй зорчих нөхцөл бүрдүүлсэн, "Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих шаардлага MNS4598-98" стандартын шаардлагыг хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэлт хийнэ.
- 3.5 Тээвэрлэгч нь хүргэлт хийх тээврийн хэрэгслийн жолоочийн хаалганы төв хэсэг, урд шилний баруун дээд буланд “итгэмжлэгдсэн тээврийн хэрэгсэл”-ийн таних тэмдгийг байрлуулна. /Хавсралт.4/
- 3.6 Тээвэрлэгч нь Иргэний хууль болон Автотээврийн тухай хуульд нийцсэн тээвэрлэлтийн гэрээг харилцагчтай байгуулж тээвэрлэлтийг гүйцэтгэнэ. Ачаа тээвэрлэлтийн гэрээг ачаа дагалдах бичгийн хэлбэрээр байгуулах бөгөөд харилцагч нь тээвэрлэгчид ачааг хүлээлгэн өгч ачаа дагалдах бичигт талууд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.
- 3.7 Ачаа тээвэрлэлтийн гэрээнд /ачаа дагалдах бичигт/ тээвэрлэгч, харилцагчийн хүлээх үүрэг, хариуцлага, тээвэрлэлтийн нөхцөл, тухайн ачаатай холбогдсон мэдээлэл, үйлчилгээний хэмжээ, тээвэрлэлтийн зай, ачааны төрлөөс хамааруулж автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан ачаа тээвэрлэлтийн жишиг тарифыг үндэслэн тогтоосон тээврийн хөлс, тээвэрлэлттэй холбогдсон бусад зардал, түүнийг төлж дуусгах эцсийн хугацаа, ачааг даатгуулах эсэх тухай заалт, ачааг дугуу тээсэн буюу хугацаа хожимдуулсан, тээвэрлэхээр хүлээн авсан ачаа, тээшийг алдсан, дутагдуулсан, гэмтээсэн, автотээврийн хэрэгслийг саатуулсан, тээврийн хөлсийг хугацаанд нь төлөөгүйгээс хүлээх хариуцлага, гэрээ цуцлах нөхцөл зэрэг тээвэрлэлттэй холбогдсон асуудлуудыг тусгана.
- 3.8 Тээвэрлэгч нь автотээврийн хэрэгслийн техникийн бүрэн бүтэн байдал, тээвэрлэлтийн нөхцөлийг хэрхэн хангасныг шалгаж, замын хуудас баталгаажуулан олгох мэргэжлийн алба, хүмүүсийг зохион байгуулан ажиллуулна.
- 3.9 Тээвэрлэгч нь ачаа тээвэрлэх зориулалтын бүх төрлийн автомашин, тэдгээрт засвар үйлчилгээ хийх, автотээврийн хэрэгслийг агуулах зориулалтын барилга байгууламж, гараж, тоног төхөөрөмжтэй, мэргэжлийн инженер, техникийн ажилтан, мэргэшсэн жолооч, засварын ажилтануудтай байна.

- 3.10 Тээвэрлэгч нь автотээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ, засварыг тогтоосон хуваарь, горимын дагуу гүйцэтгэсэн, тээвэрлэлтийн болон техник ашиглалтын шаардлага хангасан, техникийн хяналтын үзлэг, оношлогоонд заасан хугацаанд хамрагдаж тэнцсэн автотээврийн хэрэгслээр тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.
- 3.11 Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн ажил, үйлчилгээг зөвхөн тухайн ангиллын мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлэх бөгөөд автотээврийн хэрэгслийг зориулалтын гараж, зогсоол, талбайд байрлуулна.
- 3.12 Тээвэрлэгч нь барааг тээврийн хэрэгслийн эд ангид нуух, тээврийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэхэд хориотой бараа тээвэрлэх зорилгоор тоноглохыг хориглоно.

Дөрөв. ТЭЭВЭРЛЭЛТИЙН ДААТГАЛ

- 4.1 Тээвэрлэгч нь зорчигч болон гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, ачаа тээшинд учирч болзошгүй хохирлыг арилгах зорилгоор Иргэний хууль, Даатгалын тухай хууль, Автотээврийн тухай хуулинд нийцүүлсэн гэрээг даатгалын байгууллагатай урьдчилан байгуулж ажиллана.

Тав. ТЭЭВЭРЛЭГЧИЙН ИТГЭМЖЛЭЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ЦУЦЛАХ

- 5.1 Дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Биржийн Гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр тээвэрлэгчийн итгэмжлэлийг түдгэлзүүлнэ. Үүнд:
 - 5.1.1 Энэхүү журамд заасан итгэмжлэлийн шалгуурыг хангахгүй байгаа нь Биржийн ТТЛХ-ийн ээлжит болон ээлжит бус шалгалтаар тогтоогдсон;
 - 5.1.2 Биржийн холбогдох журам, заавар, шийдвэрийг биелүүлээгүй;
 - 5.1.3 Тээвэрлэгч нь харилцагчтай байгуулсан гэрээний тогтоосон маршрут, цагийн хуваарийг зөрсөн;
 - 5.1.4 Байгалийн онц аюултай үзэгдэл болон гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан энэхүү журамд заасан итгэмжлэлийн шалгуурыг хангах боломжгүй болсон;
 - 5.1.5 Тээвэрлэгч нь Биржид итгэмжлэлийг түдгэлзүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд;
- 5.2 Энэхүү журмын 2.2-т заасан шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон тээвэрлэгчийн итгэмжлэлийг 1-6 сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлнэ.
- 5.3 Итгэмжлэлийг түдгэлзүүлсэн хугацаанд тээвэрлэгчийн итгэмжлэлийн гэрчилгээг Бирж хураан авч энэ тухай өөрийн Гишүүн байгууллагуудад холбогдох мэдээллийг түгээнэ.
- 5.4 Биржийн ТТЛХ-ээс тогтоосон хугацаанд журмын 5.1-д заасан зөрчил, дутагдлыг арилгасан тухай мэдээллийг холбогдох байгууллагаар баталгаажуулан Биржид мэдэгдсэн өдрөөс хойш Биржийн итгэмжлэл сэргээх тухай шийдвэрийг ажлын 10 өдөрт багтаан шийдвэрлэнэ.
- 5.5 Дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд Биржийн тээвэрлэгчийн итгэмжлэлийг Биржийн Гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр цуцлана. Үүнд:
 - 5.5.1 Холбогдох хууль, бусад эрх зүйн баримт бичигт заасан үүргийг зохих ёсоор биелүүлээгүй нь илэрсэн.

- 5.5.2 Биржийн ТТЛХ-ээс тогтоосон хугацаанд журмын 5.1-д заасан зөрчил, дутагдлыг арилгаагүй.
- 5.5.3 Итгэмжлэгдсэн тээвэрлэгч ньнь биржийн итгэмжлэлийг цуцлах хүсэлтийг Биржид гаргасан.
- 5.5.4 Биржийн журамд заасан бусад тохиолдолд

__oOo__

Тээвэрлэгчийн итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтүүд

Биржийн итгэмжлэгдсэн тээврийн компани нь дараах шалгуурыг хангасан байна.

1. Итгэмжлэгдсэн тээврийн компани нь:
 - Жилийн борлуулалтын орлого 500 сая төгрөгнөөс дээш байх
 - Итгэмжлэгдсэн тээврийн компани нь тээвэрлэлтийн туршлагатай байх
 - Тээврийн хэрэгслүүд, жолооч нь тус компаний үндсэн болон гэрээт ажилчид байх
 - Үйл ажиллагаа тасралтгүй явуулахад хангалттай тээврийн хэрэгсэл, хүний нөөцтэй байх
 - Ачаа, тээврийн иж бүрэн даатгалтай байх
 - Компанийн хариуцлагын даатгал 1 сая ам.доллараас багагүй байх
 - Ачааны даатгал 1.5 сая ам.доллараас багагүй байх
2. Тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлага:
 - Монгол улсын тээврийн хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага хангасан байх /MNS 4598:2003, MNS 5346 : 2003 /
 - Биржийн арилжааны хүргэлтийг тасралтгүй зохион байгуулах зохих тооны тээврийн хэрэгсэлтэй байх /30-аас дээш ачааны машин байна/
 - Бүх тээврийн хэрэгслүүдэд тохирох хяналтын системтэй байх
3. Жолоочид тавигдах шаардлага:
 - Хөдөө орон нутгийн тээвэрт зохих ангилалд 3-с доошгүй жил тогтмол ажилласан жолооч байх.

Тээвэрлэгчийн итгэмжлэл хүсэгчийн бүрдүүлэх бичиг баримтууд

1. Итгэмжлэл хүссэн өргөдөл
2. Аж ахуй нэгжийн Улсын Бүртгэлийн гэрчилгээ / Нотариатаар баталгаажуулсан хуулбар/
3. Биржээс тогтоосон тээврийн хэрэгсэл, жолоочид тавигдсан шаардлагыг хангасан болохыг баталгаажуулсан баримт
4. Даатгалын компанитай байгуулсан гэрээний хуулбар
5. Үндсэн болон гэрээт ажилчдын анкет. Гэрээтэй ажилчдын гэрээ /хуулбар/
6. Тээврийн хэрэгслүүдийн 4 зүгээс авсан фото зураг /12х15 хэмжээтэй, хэвлэмэл болон цахим хэлбэрээр/



ТЭЭВЭРЛЭЛТ ХИЙСЭН МЭДЭГДЭЛ

№

20 он сар өдөр

БАРААНЫ МЭДЭЭЛЭЛ

Арилжааны хэлцлийн дугаар: _____ Тээвэрлүүлэгчийн нэр: _____

Барааны нэр: _____ Хэмжээ: _____ (кг, ш)

Хүлээн авсан газрыг хаяг: _____

Ачсан огноо: _____

Хүлээлгэн өгсөн газрын хаяг: _____

Буулгасан огноо: _____

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

Жолоочийн овог, нэр: _____

Тээврийн хэрэгслийн улсын дугаар: _____

Итгэмжлэгдсэн тээврийн хэрэгслийн таних тэмдэг

